

Тойм ба үндэслэл

<p>Үзүүлэлт</p>	<p>17. Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-ийн ач холбогдол, түүнийг хамгаалах талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд хэр өргөнөөр оролцож байгаа эсэх.</p>	
<p>Үнэлгээний хүчин зүйлүүд</p>	<p>Энэхүү үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайланг үндэсний түвшний таван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>17.1 Мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагаанууд нь холбогдох олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсийн аль болох хүртээмжтэй бөгөөд өргөн оролцоог илэрхийлдэг.</p>	<p>OD 101</p>
	<p>17.2 Соёлын биет бус өвийн тодорхой элементүүдийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулахад холбогдох олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсийн үнэ төлбөргүй, урьдчилсан, тогтвортой, мэдээлэллээр хангагдсан зөвшөөрлийг авсан байх шаардлагатай</p>	<p>OD 101</p>
	<p>17.3 СББӨ-ийн талаарх мэдлэг дээшлүүлэх үйл явцад олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсийн эрх болон тэдний ёс суртахуун, материаллаг ашиг сонирхлыг зүй ёсоор хамгаалах ёстой</p>	<p>OD 101(b), OD 101(d), OD 104, OD 171 EP 7</p>
	<p>17.4 Залуучууд нийгэм, бүлгийнхээ соёлын биет бус өвийн талаарх мэдээллийг цуглуулах, түгээх зэрэг олон нийтийн мэдлэг дээшлүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.</p>	<p>Зүйл 14(a)(i) OD 107(f)</p>
	<p>17.5 Олон нийт, бүлгүүд, хувь хүмүүс СББӨ-ийн ач холбогдлыг таниулах, түүнийг хамгаалах үйл явцдаа мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, голцуу шинэ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ба бусад бүх төрлийн хэвлэл мэдээллийг хэрэгслүүдийг ашигладаг.</p>	

<p>ТХЗ болон бусад холбогдох үзүүлэлтүүд</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд: Энэхүү үзүүлэлт нь ТХЗ-ын зорилт 11.4 буюу, “дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалалтын хүчин чармайлтыг бэхжүүлэх” зорилтыг дэмжиж, ТХЗ-ын 16.7 зорилт болох “Харилцан ойлголцдог, хүртээмжтэй, иргэдийн оролцоог дэмжсэн төлөөллийн шийдвэр гаргалтыг бүх түвшинд хангах”-д хувь нэмрээ оруулдаг юм. Мөн эмэгтэйчүүд нь нийгэм, бүлгүүд, хувь хүмүүсийн чухал хэсгийг бүрдүүлдэг учраас энэхүү үзүүлэлт нь ТХЗ-ын 5.b буюу эмэгтэйчүүдэд чадвар чадавхи олгоход мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах тухай зорилтыг дэмжсэн байдаг. Бусад үзүүлэлтүүдийн хамаарал: Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой дөрвөн үзүүлэлтийн нэг болох энэхүү үзүүлэлт нь 18-20-р үзүүлэлтүүдийг дэмжиж байдаг. Тэгэхээр энд иймэрхүү сурталчилгааны ажлууд олон нийт, бүлгүүд болон хувь хүмүүсийн оролцоог өргөжүүлэхийн сацуу тэдний эрх ашгийг ч мөн хамгаалахад гол анхаарал төвлөрч байна. Үзүүлэлт 18 нь хэвлэл мэдээллийн үүрэгт гол анхаарлаа хандуулдаг; Үзүүлэлт 19 нь мэдлэг дээшлүүлэх арга хэмжээний агуулга болон зорилгод анхаарлаа төвлөрүүлдэг бол 20-р шалгуур нь эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэлбэр, ялангуяа ёс зүйн холбогдох зарчимд нийцэж байгаа эсэхэд хамаарна</p>
<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>Конвенцийн дөрвөн зорилгын нэг нь “Соёлын биет бус өвийн ач холбогдлыг орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд сурталчлан таниулах, түүнийг харилцан хүндэтгэх явдлыг хангах” (1(с) зүйл)-д оршдог. Түүнчлэн, улс орнууд "соёлын биет бус өвийг нийгэмд хүлээн зөвшөөрүүлэх, хүндэтгэх, бэхжүүлэхдээ: олон нийтэд, тэр дундаа залуучуудад чиглэсэн мэдээллийн болон боловсрол, мэдлэг ойлголтыг нэгмэгдүүлэх хөтөлбөрүүдийг зохион байгуулахыг уриалж байдаг(14-р зүйлийн а)). Мөн Конвенц нь “ тухайн өвүүдийг бий болгох, хадгалах болон дамжуулалт хийх үйл явцад олон нийт, бүлгүүд болон хувь хүмүүсийг зохих үед” нь байж болох хамгийн өргөн оролцоогоор оролцуулахыг уриалдаг. Бусад мэдлэг нэмэгдүүлэх болон түүнийг хэрэгжүүлэх арга замд хүрэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Үйл ажиллагааны удирдамжийн IV бүлгийн OD 100-117-д тодорхой тусгасан болно. Энэхүү үзүүлэлт нь олон нийтэд мэдлэг олгох үйл ажиллагааг хэрхэн өргөн оролцоотойгоор, холбогдох ёс зүйн зарчимд хамруулж нийцүүлэн явуулах ёстойг харуулж байна.</p>

Гол нэр томъёо	<ul style="list-style-type: none"> · Нийгэмлэг, бүлгүүд эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүс · Оролцоо эсвэл оролцоо · Хамааруулсан/хамаатгасан · Үнэгүй, урьдчилсан, тогтвортой болон мэдээлэлсэн зөвшөөрөл · СББӨ-ийн элементүүд · Ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхол · Түгээн дэлгэрүүлэлт · Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)
-----------------------	---

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

Хяналтын ашиг тус	<p>Энэхүү үзүүлэлтэд хяналт тавих нь тухайн улсад СББӨ-ийн ач холбогдлын тухай мэдлэг дээшлүүлэх ажлыг Конвенц болон Үйл ажиллагааны удирдамжид нийцүүлэн явуулж байгаа эсэхийг тодорхойлоход тусална. Хяналт-шинжилгээ хийх нь тухайн үйл ажиллагаанууд нь олон нийт, бүлгүүд, хувь хүмүүсийн аль болох өргөн оролцоог хангаж байгаа эсэх ба тэдний оролцоог хамарсан, сайн дурын үндсэн дээр хийж байгаа эсэхийг үнэлэх боломжтой. Энэ нь олон нийт, бүлэг, хувь хүмүүсийн эрх, ёс суртахууны болон материаллаг ашиг сонирхлыг бүрэн хамгаалахад тусалж чадах учир залуу үеийг ч мөн үүндээ татан оролцуулна. Дэлхийн түвшинд хяналт хийх нь энэ чиглэлд шинэлэг арга хэмжээ, арга барил төлөвүүлэхэд анхаарлыг хандуулж чадна.</p>
--------------------------	---

Мэдээллийн эх сурвалж, цуглуулга

Ихэнх тохиолдолд мэдээллийн үндсэн эх сурвалж нь мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн салбарын төрийн эрх бүхий байгууллагууд байж болно. Хэрэв төр нь зөвлөлдөх байгууллага, зохицуулалтын механизмтай бол түүнд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл эсвэл мэдлэг дээшлүүлэхэд үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бусад хүмүүс багтаж, нэмэлт мэдээллээр хангаж болно. Мөн Үнэлгээний хүчин зүйлс 17.2 ба 17.3 нь мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ёстой зарчмуудыг тодорхойлсон хэвлэгдсэн код эсвэл удирдамжийг илэрхийлж байх боломжтой. Мэдлэг дээшлүүлэх ихэнх үйл ажиллагааны адил мэдээ мэдээллүүд нь ихэвчлэн бэлэн байх магадлалтай байдаг.

Боломжит мэдээллийн эх сурвалжууд

- Мэдлэг дээшлүүлэх талаарх хэвлэл нийтлэл, тайлангууд болон материалуудын цуглуулга
- Мэдээлэл дээшлүүлэх талаарх хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хамаарах хүмүүст зориулсан ёс зүйн дүрэм эсвэл удирдамж
- Оюуны өмчийн талаар хууль тогтоомж, бодлогын хэрэгсэл
- Мэдээллийн яам, Харилцаа холбооны яам ба/эсвэл Залуучуудын яамны вэбсайтууд болон тайлангууд
- Вебсайт, блог, видео бүртгэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байршуулсан нийтлэлүүд
- Сошиал медиа бүлгүүд болон нийгэмлэгүүд